



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР

**АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫН
2013 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**



АГУУЛГА

2

- ❖ 2013 онд дэвшүүлсэн зорилт
- ❖ 2013 онд хийж гүйцэтгэсэн ажлууд
- ❖ Дүгнэлт
- ❖ Цаашдын зорилт, тулгамдаж буй асуудлууд



2013 онд дэвшүүлсэн зорилтууд

3

- ✓ Улсын төсвөөс санхүүжих 1:200 000, 1:50 000-ны масштабтай УГЗ, ГЗЕЭА болон сэдэвчилсэн судалгааны ажлуудыг сонгосон талбайн хэмжээнд чанарын өндөр түвшинд хэрэгжүүлэхэд хяналт тавих;
- ✓ Хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн гүйцэтгэж байгаа геологи-хайгуулын ажилд хяналт тавих, завсрын болон үр дүнгийн тайланг хүлээн авах, ашигт малтмалын нөөцийг нэмэгдүүлж, нэгдсэн мэдээллийн санг бий болгох;
- ✓ Төмрийн уурхай, үйлдвэрүүдийн техник технологийн түвшинд үнэлгээ хийх;
- ✓ “Стратегийн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх” зорилтын хүрээнд УИХ-ын 27-р тогтоолоор батлагдсан 15 ордын хил хязгаарыг шинэчлэн тогтоох, шинээр стратегийн ордод хамааруулах ордуудын судалгаа, санал боловсруулах;



2013 онд дэвшүүлсэн зорилтууд

4

- ✓ “Гол мөрний урсац бүрдэх эх, ойн сан, усан сан бүхий хамгаалалтын газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийг хэрэгжүүлэх, холбогдох судалгаа мэдээллээр ханган ажиллах
- ✓ Уул уурхайн үйлдвэрлэлд идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн талаар дэлгэрэнгүй судалгаа гаргаж, сан бий болгох;
- ✓ Нүүрсний орд, үйлдвэрүүдийн талаарх дэлгэрэнгүй судалгаа гаргах;
- ✓ Нүүрс боловсруулах технологийн судалгаа хийх;
- ✓ Эрчим хүчний уурхайнуудын өвлийн бэлтгэлийг хангуулах;



2013 онд дэвшүүлсэн зорилтууд

5

- ✓ Геологи уул уурхайн кадастрын компьютержсэн системийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох;
- ✓ Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлэх үйлчилгээний чанарыг дээшлүүлж, шат дамжлагыг багасгах;
- ✓ Уул уурхайн шинжилгээ туршилтын лабораторид орчин үеийн стандартуудыг нэвтрүүлэн ашиглах замаар шинжилгээ, туршилтын ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах;
- ✓ Улсын төсвийн орлогын даалгаврыг ханган биелүүлэх;
- ✓ Байгууллагын төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангаж, хүний нөөцийг чадваржуулах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, санхүү бүртгэлийг сайжруулах;
- ✓ Агентлагийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах;
- ✓ Авлигатай тэмцэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх;
- ✓ Бодлогын баримт бичгүүд, хууль тогтоомж, холбогдох эрх зүйн актын хэрэгжилтэд хийх үнэлгээг тогтмолжуулах, үр дүнд суурилсан дотоод хяналтын тогтолцоог бий болгох, хөгжүүлэх, улмаар газрын үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлж, хариуцлагыг өндөржүүлэх;
- ✓ АМГ-ын статистик мэдээллийн сан бүрдүүлж улирал тутам уул уурхайн салбарын статистик мэдээ гарган хэрэглэгчдэд түгээж хэвших;



Ашигт малтмалын газар

6

2013 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУД



1. ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР



Геологийн судалгааны төслүүд

8

2013 онд УТХ-өөр УГЗ-200 төслийн тайлангаа хамгаалж байгаа 4 төсөл, үргэлжлэн хэрэгжих 4, шинээр хэрэгжиж эхэлсэн 4, 1:50 000-ны масштабын ГЗЕЭА-ын эцсийн үр дүнгийн тайлан хамгаалсан 18 төсөл, хээрийн судалгааны ажилтай 27, сэдэвчилсэн судалгааны үр дүнгийн тайлан хамгаалсан 1 төсөл, хээрийн судалгаатай 1 төсөл, хамтын ажиллагааны 3 төсөл нийт 62 төсөл хэрэгжүүллээ.

НИЙТ 7,2 ТЭРБУМ ТӨГРӨГ ТӨЛӨВЛӨГДӨЖ ӨНӨӨДРИЙН БАЙДЛААР 6,8 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭЭД БАЙНА

Геологийн судалгааны ажлын төрөл	Хүрсэн түвшин (%)
1:200000-ны масштабын геологийн зураглал	99,1
1:50 000-ны масштабын ГЗЕЭА	29,7
Гидрогеологийн зураглал	84,0
Агаарын геофизикийн судалгаа	38,0

ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТҮВШИН



УТХ-өөр 2013 онд гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлууд

9

1	Геологийн 1:50000-ны масштабтай геологийн зураглал ерөнхий эрлийн ажил	<p>- 2011-2013 онд хэрэгжүүлсэн Холбоо нуур-50, Нарт толгой-50, Дүнгээн уул-50 зэрэг нийт 18 төслүүдийн эцсийн үр дүнгийн тайланг хүлээн авч ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн.</p> <p>- 2013 онд Мандалговь-50, Манлай-50, Бардам уул-50, Замлин богд-50 зэрэг 27 төслийн судалгааны ажил 29257.05 км² талбайд үргэлжлэн хийгдэж байна</p>
2	Улсын геологийн 1:200000-ны масштабтай иж бүрдэл зураг зохиох ажил	<p>- 2010-2013 онд 367 496,3 км² талбайд хэрэгжүүлсэн УГЗ-200 Өмнөд-Монгол-V, УГЗ-200 Өмнөд-Монгол-IV, УГЗ-200 Дорнод-Монгол-IV, УГЗ-200 Баруун-Монгол-IV төслүүдийн тайланг хүлээн авч ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн.</p> <p>- 401 021,14 км² талбайд үргэлжлэн хэрэгжиж байгаа 4 төсөл, энэ жил шинээр 287,925 км² талбайд хийгдэх 4 төслийн судалгааны ажлыг эхлүүлсэн.</p> <p>Энэ ажил хийгдсэнээр 2016 онд Монгол орны нутаг дэвсгэр 100% бүрхэгдэнэ.</p>
3	Сэдэвчилсэн судалгаа	<p>- Өмнийн говийн районд гидрогеологи-экологийн судалгааг 64749 км² талбайд явуулсан “Өмнийн говь” төсөл хэрэгжиж тайланг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн.</p> <p>- Өмнөд говийн бүсэд Өмнөговь аймгийн Баян-овоо, Даланзадгад, Ханбогд, Номгон, Хүрмэн, Манлай сумдын 74189,28км² талбайд 1:200 000-ны геологи, гидрогеологи, геоэкологийн иж бүрдэл зураг зохиох, геоэкологийн үнэлгээ өгөх “Өмнөд говь” төсөл хэрэгжиж байна.</p>
4	Хамтын ажиллагааны төслүүд	<p>- ОХУ, БНХАУ, БНСУ, Казакстан улстай хамтарсан Хойд-Төв-Зүүн Азийн 3 хэмжээст геологийн структурууд ба металлогений төсөл</p> <p>-Монгол улс, БНСУ-тай хамтарсан Хангайн хүдрийн бүсийн геологийн судалгааны төсөл</p> <p>- Монгол улс, БНЧехУ-тай хамтарсан Монгол Алтайн талбайд 1:50 000-ын масштабтай геологийн зураглал ерөнхий эрлийн ажлын төсөл хэрэгжиж байна.</p>



Хувийн хөрөнгөөр хийгдэх ГХА

10

2013 онд хувийн хөрөнгөөр хийгдсэн геологи хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө, тайлан, үр дүнгийн тайлангийн тухай мэдээлэл



2012 оны геологи, хайгуулын ажлын 1834 тайлан, 2013 оны 1480 төлөвлөгөө хүлээн авсан.



Геологи мэдээллийн төв архив

11

ХАДГАЛАМЖИЙН САН:

Монгол орны нутаг дэвсгэр дээр 1925 оноос эхлэн хийгдсэн геологи хайгуулын ажлын үр дүнд боловсруулсан геологийн тайлан, эрдэс баялгийн шинжилгээ туршилтын үр дүнгийн тухай дүгнэлт, ТЭЗҮ зэрэг баримт бичгүүд, анхдагч материалууд нь тус төвийн фондод 31034 орчим ном, 386000 ширхэг зураг хэлбэрээр хадгалагдаж байна.



2013 онд Геологийн мэдээллийн төв архивт төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн 13 төслийн үр дүнгийн тайлан, хувийн хөрөнгөөр хийсэн нөөцийн үр дүнгийн 268 тайлан, 121 орд ашиглах ТЭЗҮ, эдгээртэй холбоотой хээрийн судалгааны 87 ордын 137 уут анхдагч баримтуудыг хянаж хүлээн авч улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн.



Геологи мэдээллийн төв архив

12



ЧУЛУУН ДЭЭЖИЙН САН:

- Чулуун дээжийн сангийн байрыг 238 сая төгрөгөөр засварлан, 2014 оноос үйл ажиллагааг нь эхлүүлнэ.
- 2013 онд аж ахуйн нэгжүүдээс 243 чулуун дээж, 1040 тунгалаг шлиф, 158 аншлиф шинээр хүлээн авч, нэгдсэн санг зурагтай нь холбох, ажил хийгдсэн.

ГЕОЛОГИЙН АЛБА



ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛ



Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл

14

Ашигт малтмалын хайгуулын ажлын үр дүнг хэлэлцэх салбар хуралдаан

- Хурлын тоо 23
- Хэлэлцсэн тайлангийн тоо 211
- Хуралдааны дүгнэлтийн тоо 183
- Хуралдааны тэмдэглэлийн тоо 23
- Геологийн архивт тушаасан тайлангийн тоо 146

Ашигт малтмал ашиглах ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаан

- Хурлын тоо 21
- Хэлэлцсэн тайлангийн тоо 174
- Хуралдааны дүгнэлтийн тоо 151
- Хуралдааны тэмдэглэлийн тоо 21



2013 онд нэмэгдсэн ашигт малтмалын нөөц

15

№	Ашигт малтмалын төрөл	Ордын тоо	2013 онд бүртгэгдсэн нөөц
1	Алтны үндсэн /тн/	10	41,1
2	Алтны шороон орд /тн/	18	4,6
3	Мөнгө / тн /	дагалдах а.м	65,1
4	Зэс /мян.тн/	2 /дагалдах а.м/	63,4
5	Молибден /мян.тн/	дагалдах а.м	39,6
6	Цайр /мян.тн /	13	178,2
7	Төмөр /сая.тн/	6	30,3
8	Гянтболд /мян.тн /	2 /дагалдах а.м/	111,7
9	Хар тугалга /мян.тн /	13	11,6
10	Нүүрс /сая.тн/	16	2 906,2
11	Хайлуур жонш /сая.тн /	16	2,8
12	Барилгын чулуу /сая м3/	17	151,4
13	Шохойн чулуу /сая тн/	11	9,5
14	Тоосгоны шавар /сая м3/	10	77,2
15	Элс хайрга /сая м3/	8	12,7
16	Гөлтгөнө /сая м3/	1	2,4
17	Газрын ховор элемент /тн/	2	51,8




2. УУЛ УУРХАЙН ЧИГЛЭЛЭЭР



УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТАЙЛАН

17



2011 оноос Уул уурхайн хэлтэс төлөвлөгөө, тайланг 100% цахим хэлбэрээр авч байна.

Нүүрсний уурхайнуудын төлөвлөгөө, тайланг цахимаар авах бэлтгэл ажлууд хийгдэж байна.



Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа

- “Төмрийн хүдэр олборлолт ба хэтийн төлөв”, “Гянтболд олборлолт ба хэтийн төлөв” гэсэн гарын авлага гаргасан.
- “Алт ба зэсийн нийлүүлэлт ба зах зээлийн байдал” гэсэн гарын авлага гаргасан.
- “Уул уурхайн салбарын ачаалал ба татварын шинэчлэлийн судалгаа” гэсэн гарын авлагыг гаргасан.

Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний 2012 оны 12 дугаар сард, баримттай жижиг умайг мэдэгдэв.

Монгол Улсын 2012 оны 12 дугаар сарын 1-2012 оны 12 дугаар сарын 31-ийн үеийн уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээний үзүүлэлтүүдийг дараах байдлаар танилцуулж байна. 2012 оны 12 дугаар сард уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээний үзүүлэлтүүдийг дараах байдлаар танилцуулж байна.

Тусгайлан 2012 оны 12 дугаар сард Монголын уул уурхайн салбарын үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээний үзүүлэлтүүдийг дараах байдлаар танилцуулж байна.

Төрөл	2012 оны 12 сард	2012 оны 11 сард
Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл	1,824.22	1,824.22
Худалдаа	7,992.92	7,992.92
Хэрэглээ	2,179.44	2,179.44
Цэвэр үрүн	22,824.22	22,824.22

МОНГО ОЛБОРЛОЛТ, ХАВГАХ АЖЛААНЫ ГЭРЭЭНИЙ ХЭЛТЭС

2012 оны 12 сарын 17

1. Зөвхөнхө мөнгөн бэрх дүн зардалтай уурхайн салбарын үйлдвэрлэл 2012 оны 12 дугаар сард 14-аар өсчээ. Өндөр аж үйлдвэр, илүүтэйгээ буурч буцаж ирэхийн үр жингээс үргэлжлэн өсчээ. Зөвхөнхө мөнгөн бэрх дүн зардалтай уурхайн салбарын үйлдвэрлэл 2012 оны 12 дугаар сард өсчөвч, өөрөөр хэлбэл өсөхийн зардалтай 47 өсчөөрхөгч, өөрөөр хэлбэл 5.5 өсчөөрхөгчөөр өсчөөрхөгч байна.

Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл	Төрөл	2012 оны 12 сард	2012 оны 11 сард
1. Алт	Алслагчид	1895.21	20.0%
2. Зэс	Алслагчид	33.51	25.53%
3. Гянтболд	Алслагчид	2023.3	1.83%
4. Төмөр хүдэр	Алслагчид	2292	5.83%
5. Цэвэр мөнгө	Алслагчид	26283	1.93%
6. Цэвэр зэс	Алслагчид	22208	3.93%
7. Цэвэр гянтболд	Алслагчид	11217	0.53%
8. Цэвэр төмөр хүдэр	Алслагчид	18888	
9. Цэвэр мөнгө	Алслагчид	22828	
10. Цэвэр зэс	Алслагчид	18888	
11. Цэвэр гянтболд	Алслагчид	18888	
12. Цэвэр төмөр хүдэр	Алслагчид	18888	

Алтын үнэ


Мөнгөний үнэ

Зэсийн үнэ

Төмрийн үнэ

МОНГО ОЛБОРЛОЛТ, ХАВГАХ АЖЛААНЫ ГЭРЭЭНИЙ ХЭЛТЭС

2012 оны 12 сарын 17





2012 онд нөөцийн хөдөлгөөний бүртгэл хийгдсэн ордууд

19

/ 2013.12.10-ны өдрийн байдлаар /

АМ-ын төрөл	Ордын тоо
Алт	47
Молибден	1
Зэс, молибдени	1
Цайр	1
Төмөр	14
Гянтболд	4
Нийт металл ашигт малтмалын	68

АМ-ын төрөл	Ордын тоо
Шохой	11
Тоосгоны шавар	19
Баргилт	1
Гөлтгөнө	1
Элс хайрга	20
Барилгын чулуу	8
Жонш	23
Нийт металл бус ашигт малтмалын	83

Ашиглалтын тусгай зөвшөөрлийн нөөцийн судалгаа

	НИЙТ	Ашигт малтмалын ашиглах нөөцтэй	Ашигт малтмалын ашиглах нөөцгүй АТЗ	Тодорхойгүй
2009.07	1118	742	118	258
2012.06	1173	943	88	142
2013.12	1229	1127	50	38



Стратегийн ордуудын чиглэлээр

20

- Стратегийн ач холбогдолтой байж болох 33 ордоос нүүрсний **16**, металл болон металл бус **17** ордын мэдээллийг 56 үзүүлэлтээр нэгтгэн бэлтгэсэн.

- Мөн 9 ордыг нэмж судлан дээрх 56 төрлийн үндсэн үзүүлэлтээр мэдээлэл бэлтгэж хүргүүлснээс:

- Алтан цагаан овооны алт-холимог металлын орд
- Лугийн гол газрын ховор элементийн орд
- Мушгиа худаг
- Хотгор газрын ховор элементийн орд
- Хөшөөтийн орд
- Цайдам нуурын орд
- Халзан бүргэдэй газрын ховор элементийн ордыг

стратегийн ордод хамруулахаар 2013/05/30-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлэн, 2013/05/31-ны өдөр УИХ-д өргөн барьсан.




БИЧИЛ УУРХАЙ


2013 онд нийт 15 аймгаас Бичил уурхайн зориулалтаар ашиглах талбайн хүсэлт ирүүлснээс бүгд хуулиар хориглосон талбайтай давхцалтай тул боломжгүй дүгнэлт гарсан.

2013 онд нийт 20 аймгаас бичил уурхайчдын болон ХАМО иргэдийн мэдээ ирүүлсэн.


- Бичил уурхайгаар ашиглагдаж байгаа талбай
- Нөхөн сэргээсэн талбай



Бичил уурхайн зориулалтаар ашиглах боломжгүй талбайн дүгнэлт (2013 он)



Нөхөрлөлийн тоо



2013 онд Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох боломжтой дүгнэлт гарсан 10 аймгийн 111 нөхөрлөлийн 1186 иргэд 6 аймагт үйл ажиллагаа явуулав.



Уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэл

22

Ашигт малтмалын төрөл	Хэмжих нэгж	2011	2012	2013*
Алт	кг	4350.5	4023.3	7615.3
Гянтболд	мян.тн	0.02	129.4	-
Зэсийн баяжмал	мян.тн	513.695	517.8	470.2
Катодын зэс	тн	2397	2121	2146.6
Молибдений баяжмал	тн	1956.652	3933	2777.0
Жоншны баяжмал	мян.тн	243.41	461	197.8
Цайр	мян.тн	105.85	125.2	120.9
Төмөр	мян.тн	4663.313	6138.5	5952.0
Тоосго	сая.ш	28.142	19.401	28.1
Шохойн чулуу	мян.тн	654.73	502.702	-
Элс, хайрга	мян.м3	629.8	941.32	-
Гөлтгөнө	мян.тн	9.175	3.292	-
Тугалга	мян.тн	54.8	98.598	-
Нүүрс	мян.тн	32994	31919.1	32347.8

* АМТХ-ийн 48.6.3.-т заасны дагуу тухайн жилийн үйл ажиллагааны тайланг дараа оны 02/15-ны өдрийн дотор ирүүлдэг учир 2013 оны бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг гаргах хугацаа болоогүй байна.

2013 оны мэдээг Сорьцын хяналтын улсын алба, Гаалийн ерөнхий газар болон Үндэсний статистикийн хорооны мэдээлэлд тулгуурлан гаргав.



2013-2014 оны эрчим хүчний нүүрс үйлдвэрлэгч уурхайнуудын авахад бэлэн буюу нээгдсэн нүүрсний нөөц

23

№	Аж ахуйн нэгжийн нэр	12 дүгээр сарын 1-ны байдлаар нээсэн буюу авахад бэлэн нөөц /МЯН.ТН/
1	“Багануур” ХК	668.0
2	“Шивээ-Овоо” ХК	520.0
3	“Шарын гол” ХК	50.0
4	“Адуунчулуун” ХК	170.0
	Эрчим хүчний нүүрс, дүн	1408.0

2013-2014 оны эрчим хүчний нүүрс үйлдвэрлэгч уурхайнууд 1408.0 мянган тонн авахад бэлэн буюу нээсэн нүүрсний нөөцтэй байна.



Томилолтоор ажилласан байдал

24

	тоон утга	Томилолтын чиглэл
➤ Чиглэлийн тоо	52	• Баруун бүс
➤ Мэргэжилтны тоо	104	• Төвийн бүс
➤ Хоног	282	• Зүүн
		• Говь

АМГ-ын даргын баталсан төлөвлөгөөт томилолтоос гадна дараах холбогдох байгууллагуудтай хамтран томилолтоор ажиллав:

- Улсын их хурлын гишүүд
- Уул уурхайн яам
- Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
- Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
- Улсын мөрдөн байцаах газар
- Эрүүгийн цагдаагийн газар
- Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
- Нийслэлийн БОНХГ
- Нийслэлийн ҮХААГ
- Геологийн төв лаборатори
- Монголын уул уурхайн үндэсний ассоциаци
- Монголын металлургийн холбоо
- Өрөмдлөгийн холбоо
- Швейцарийн хөгжлийн агентлаг
- Хэвлэл мэдээллийн байгууллагууд



Удирдах дээд байгууллагуудыг мэдээллээр хангасан байдал

25

Мэдээллийн тоо



АМГ-аас явуулсан бичгүүдийг хуудасны тоогоор харуулбал:

он	Архивын нэгж	Хуудасны тоо
2011	73	18 250
2012	70	17 500
2013	68	17 000

Аж ахуйн нэгж байгууллагууд руу 5100 гаруй албан тоот илгээсэн.




3. ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН КАДАСТРЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР



Ашигт малтмалын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл

27


2013.12.13-ны өдрийн байдлаар нийтдээ 15 сая га талбайг хамарсан ашигт малтмалын 3050 тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна. Энэ нь Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 9.6 хувийг эзэлж байна.





Хүлээн авсан өргөдлийн тоо, 2012-2013

28





Өргөдөл хүлээн авч хянан шийдвэрлэх, тусгай зөвшөөрлийн бүртгэлд орох өөрчлөлтийг бүртгэх

29



Нийт 528 өргөдөл хүлээн авч бүртгэсэн ба тайлант хугацаанд 509 өргөдлийг хянан, зохих шийдвэр гаргаж, хавсралтад тэмдэглэгээ хийн, эзэмшигчдэд мэдэгдэл, тусгай зөвшөөрлийг хүлээлгэн өгөх үйлчилгээг үзүүлсэн ба үлдэх өргөдлүүд хуулийн хугацаандаа хянагдах шатандаа явж байна.

КАДАСТРЫН ХЭЛТЭС



Өргөдөл хүлээн авч хянан шийдвэрлэх, тусгай зөвшөөрлийн бүртгэлд орох өөрчлөлтийг бүртгэх

30





Компьютержсэн кадастрын систем

31

КАДАСТРЫН ХЭЛТЭС


Кадастрын бүртгэлийн систем
Ашигт малтмалын газар

Тавтай морилно уу LicenseHolder! [Гарах]

Эхлэл Хүсэлт гаргах ТЗ-ийн өөрчлөлт Манай ТЗ-ийн өөрчлөлтийн мэдээ Тусгай зөвшөөрлүүд Манай тусгай зөвшөөрөл Тусгай хэрэгцээний газар Баримт бичиг Газрын зураг


Кадастрын бүртгэлийн систем

Тусгай зөвшөөрлийн эрх олголтын үйл ажиллагаа болон олон нийтэд үйлчлэх үйлчилгээг бэхжүүлж сайжруулах зорилготой Кадастрын бүртгэлийн системийг АМГ-ын Кадастрын хэлтэст хэрэгжүүлж дууссан. Системийг ашигласнаар тусгай зөвшөөрлийн эрх олголтын ажиллагааг хурдан шуурхай, чанартай болгох, кадастрын мэргэжилтнүүдийн хөдөлмөрийн бүтээж дээшлэх, үйлчилгээний чанар агууламж сайжирч кадастрын үйл ажиллагаанд гарах алдааг цөөрүүлэх, татгалзах өргөдлийн тоо цөөрч кадастрын бүртгэлийн ил тод байдалд ахиц гарах нөхцөл бүрдсэн. Түүнчлэн кадастрын үйл ажиллагааны үндсэн горимууд автоматчлагдаж энгийн хялбар, түргэн шуурхай болсон.




Тусгай зөвшөөрлүүд

Тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл. Дэлгэрэнгүйг нэвтрэнээр авч болно.




ТЗ-ийн өөрчлөлт

Тусгай зөвшөөрлийн өөрчлөлттэй холбоотой мэдээлэл. Дэлгэрэнгүйг нэвтрэнээр авч болно.




Тусгай хэрэгцээний газар

Тусгай газрын тухай мэдээлэл.



Баримт бичиг

Өргөдлийн баримт бичгүүдийг татах



Газрын зураг

Зураг үзүүлэгч нь бүх тусгай зөвшөөрлийн болон холбогдох нэмэлт өгөгдлийг харуулна.

Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн статистик					
Төрөл	Тоолох	Тоолох (%)	Талбай /га	Талбай /га/ (%)	Нийт газар нутаг (€)
Нийт	3504	100%	20036875.0	100%	12.81%
Ашиглалтын тусгай зөвшөөрөл	1249	35,64%	919591.89	4,59%	0,59%
Хайгуулын тусгай зөвшөөрөл	2255	64,36%	19117283.1	95,41%	12,22%

© 2013 GAF AG | info@gaf.de Хэвлэх

Дэлхийн банкны “Засаглалыг дэмжих төсөл”-ийн хүрээнд Кадастрын бүртгэлийн системийг бүрэн автоматжуулах төслийг хэрэгжүүлэн, үйл ажиллагаанд нэвтрүүлэн, ашиглаж байна.

Дэлхийн банкны санхүүжилтаар хэрэгжиж буй “Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлэх техник туслалцааны төсөл”-ийн дэд хэсэг болох “Кадастрын хэлтсийн бүртгэлийн системийг интернэтийн орчинд байршуулах” төслөөр УУККСистемийг байгууллагын веб хуудсанд байршуулахад бэлэн болсон.



4. УУЛ УУРХАЙН ШИНЖИЛГЭЭ, ТУРШИЛТЫН ЛАБОРАТОРИ



МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ

33

Лабораторийн итгэмжлэл сунгуулах ажлын хүрээнд MNS ISO/IEC 17025:2007 стандартын дагуу Лабораторийн Чанарын гарын авлага, үйл ажиллагааны 22 журам, стандарт аргын заавар, бүртгэл г.м. нийт 54 баримтыг шинэчлэн боловсруулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлсний дүнд СХЗГ-ын итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтүүдийг ханган лабораторийн итгэмжлэлийг 4 жилийн хугацаагаар сунгууллаа.



УУЛ УУРХАЙН ШИНЖИЛГЭЭ, ТУРШИЛТЫН ЛАБОРАТОРИ



ЛАБОРАТОРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

34



УУЯ-наас захиалсан тендерийн дагуу лабораторид 285 сая төгрөгийн өртөг бүхийн 7 нэр төрлийн багаж, тоног төхөөрөмжийг шинээр авч суурилуулан ашиглалтанд орууллаа.

БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжсэн төслийн хүрээнд лабораторийн шинжилгээний 10 нэр төрлийн үндсэн багаж, тоног төхөөрөмжүүдийг шилжүүлэн авч ажиллуулж эхэллээ.





ШИНЖИЛГЭЭ ТУРШИЛТЫН АЖИЛ

35

Лабораторид 2013 онд нийтдээ 17 нэр төрлийн шинжилгээний багаж тоног төхөөрөмж шинээр суурилуулж, лабораторийн хүчин чадлыг өсгөснөөр ашигт малтмалын найрлага, бүтэц, физик, хими, механик шинж чанарыг гүнзгийрүүлэн судлах боломж бүхий элементийн, спектрометрийн, петрографийн, хроматографийн, калориметрийн шинжилгээг орчин үеийн багажит анализын аргаар гүйцэтгэх боломжтой боллоо.



2013 оны жилийн ажлын үр дүнд үйлчилгээний хүрээгээ 15 төрлөөр өргөжүүлэн, нийт 31 нэр төрлийн шинжилгээ туршилтын ажил гүйцэтгэх техникийн боломжийг бүрдүүлж лабораторийн чадавхийг 2 дахин нэмэгдүүллээ.

УУЛ УУРХАЙН ШИНЖИЛГЭЭ, ТУРШИЛТЫН ЛАБОРАТОРИ



5. ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, СТАТ ИСТИК МЭДЭЭЛЛИЙН ЧИГЛЭЛЭЭР



ХШҮ-НИЙ АЖЛУУДЫН ТӨРӨЛ

Бодлогын баримт бичгүүд, холбогдох эрх зүйн акт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийж хуулийн хугацаанд нь УУЯ-нд хүргүүлсэн.





ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛ

Хяналт-шинжилгээ үнэлгээний гол ажлуудаас:

- КХ-ийн тусгай зөвшөөрлийн фондын үйл ажиллагаанд ;
- 2006 оноос хойш сэргээсэн тусгай зөвшөөрлийн хувийн хэргийн материалыг кадастрын системд бүртгэсэн байдалд тулгалт;
- АМГ-ын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа;
- АМГ-ын нийт албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгаа;
- Уул уурхайн хэлтсийн зарим үйл ажиллагаа хийсэн хяналт ;
- Геологийн албаны зарим үйл ажиллагаа хийсэн хяналт ;
- ЗД төсөл буюу “Хойд-Төв-Зүүн Азийн геологийн гурван хэмжээст структуууд ба металлогени” төслийн үйл ажиллагаанд;
- АМГ-ын гадаад ба дотоод томилолтын гүйцэтгэл болон санхүүгийн зарцуулалтын байдалд;
- АМГ-ын захиргааны албан хаагчдын ажлын ерөнхий ачаалалд;



ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛ

Санхүүгийн дотоод аудит:

- АМГ-ын санхүүгийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд хагас бүтэн жилээр;
- Бараа материал худалдан авалт;
- ГА-ны Улсын төсөв бүрдүүлэх үйл ажиллагаанд;
- Үйлчилгээний орлого, тусгай зөвшөөрлийн төлбөрт;
- Өмнөд монгол”, “Баруун монгол”, “Дорнод монгол” төслүүдийн 2012 оны санхүүгийн зарцуулалт, тайлагналт;



ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛ


Хяналт-шинжилгээ үнэлгээ хийснээр дараах ҮР ДҮНД хүрээд байна.

1. Улирал бүр алба, хэлтсийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийснээр хоцрогдолтой болон хийгдээгүй ажил үйлчилгээг тодорхой болгон, арга хэмжээ авч төлөвлөгөөний хэрэгжилт сайжирсан.
2. Санхүүгийн дотоод аудитын хяналтыг тогтмолжуулсан бөгөөд үр дүнд нь санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналт, төсвийн хөрөнгийн зарцуулалт, худалдан авалттай холбоотой зөрчил дутагдлууд бүрэн арилсан.
3. Газрын хэмжээнд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдэд хийсэн хяналтуудын үр дүнд төслийн үйл ажиллагаа, түүний үр дүн, санхүүгийн зарцуулалтын байдал эрс сайжирсан.
4. Эрсдэл өндөртэй ажил үйлчилгээ, арга хэмжээг сонгон авч хяналт шинжилгээнүүд хийснээр зөрчил дутагдлыг тухай бүр илрүүлэн засч, улмаар тухайн ажил үйлчилгээний чанар, үр дүн сайжирсан.
5. АМГ-ын үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судлагааг хийснээр сэтгэл ханамж тааруу ажил үйлчилгээг илрүүлэн, улмаар нарийвчилсан үнэлгээ хийн, шалтгаан нөхцлийг тодруулан засч сайжруулах төлөвлөгөө гарган ажиллаж байна.
6. ГА болон УУХ-ийн үйл ажиллагаа хэрэгжилт, ажлын байрны зохион байгуулалтын дутагдалтай тал, үйл ажиллагааны давхардал, орхигдол зэргийг нарийвчлан судлан гаргаж ирсэн.
7. Цаг ашиглалтын байдалд байнгын хяналтыг хэрэгжүүлснээр нийт албан хаагчдын цаг ашиглалт өмнөх оноос мэдэгдэхүйц сайжирсан.



СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

- ✓ АМГ-ын бүртгэл, статистикийн өнөөгийн байдлыг судалж **статистик мэдээллийн нэгдсэн санг** боломжит үзүүлэлтүүдээр бүрдүүлээд байна.
- ✓ Уул уурхайн салбарын **статистик мэдээг боловсруулж, сар бүр товхимол бэлтгэн** гарган тогтмолжуулж, вэб-д байршуулж байна.






6. ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР



Бичиг хэргийн эргэлт

43



Даргын тушаал – 473 ш
Албан даалгавар – 14 ш
Архивт – 82 боть



Шагнал, сургалт, тусламжийн хэмжээ /хүний тоогоор/

44



- Түлээ нүүрсний хөнгөлөлт 14 хүнд 2,8 сая төгрөг,
- Урамшуулал 17 хүнд 2,5 сая төгрөг,
- Тусламж 27 хүнд 42,4 сая төгрөг
- Нөхөн олговор 6 хүнд 15,7 сая төгрөг,
- Шагнал 7 /төрийн дээд-3, яамны-4/



Гадаад, дотоод сургалт:

45

-Байгууллагын ажилтан албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор сургалт, давтан сургалтыг тогтмол дэмжин ажиллаж байна. Батлагдсан төсвөөс гадна бусад эх үүсвэрүүдийг эрэлхийлэн сургалтын зардлыг шийдвэрлэх чиглэлээр анхааран ажиллаж байна.

Сургалтын төрөл		Хамрагдсан хүний тоо (давхардсан тоогоор)
Гадаад	Богино	24
	Дунд	2
	Урт	6
Дотоод	Богино	12
	Дунд	21
	Урт	14

- Нийт албан хаагчдын 40 хувь нь сургалт, давтан сургалтад хамрагдсан
- Гадаад сургалтад 2900 ам.доллар,
- Дотоодын богино хугацааны сургалтад 824,4 мян.төгрөг
- Дотоодын урт хугацааны сургалтад 21,1 сая төгрөг



САНХҮҮГИЙН БОЛОН ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

46

- ❖ Байгууллагын спортын аварга шалгаруулах тэмцээнийг 5 төрлөөр, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд мод тарих ажлыг тус тус зохион байгууллаа. Мөн тамхины хяналтын тухай хууль шинээр батлагдсантай холбоотой зарим зохион байгууллалтын ажлуудыг хийж гүйцэтгэсэн.
- ❖ “Цахим засаглал” хөтөлбөрийн хүрээнд төрийн байгууллагууд хооронд мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээнд хамрагдах техникийн бэлтгэл хангасан.
- ❖ Хүний нөөц, бичиг хэргийн мэдээллийн нэгдсэн сантай болсон.
- ❖ Орон сууцны зээлд хамрагдах хүсэлт гаргасан ажилтнуудыг дэмжих зорилгоор “Улаанбаатар хотын” банктай сарын 1,7%-ийн хүүтэй зээлд хамруулах гэрээг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн.
- ❖ “Голомт” банкнаас авах цалингийн зээлийн хүү 2,0-1,7% байсныг бууруулж 1,7-1,5%
- ❖ Байгууллагын ажлын хэрэгцээнд энгийн хэрэглээний 67, тусгай зориулалтын 1 компьютер, 100 ш тог баригч, 1 плоттер, 5 ш принтер худалдан авсан.
- ❖ Компьютерийн хамгаалалтын програмын шинэчлэлтийг хийн, Kaspersky 6.0 хувилбарыг 8.0 болгож нийт 250 ш эрхтэй байсныг 280 болгон нэмэгдүүлсэн.
- ❖ Санхүү бүртгэлийн “Unicus” програмыг шинээр суулган, ашиглаж эхэлснээр санхүүгийн тайлангуудыг шууд интернэт орчинд боловсруулан гаргах боломжтой болсон.
- ❖ Байгууллагын дотоод журам зөрчсөн 23 ажилтанд сахилгын арга хэмжээ авсан.



АГЕНТЛАГИЙН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ:

47

№	Мэдээллийн төрөл		Тоо хэмжээ
1	11-11 ТӨВ	Санал	58
2		Гомдол	5
3		Шүүмжлэл	4
4	Веб хуудсанд оруулсан		160
5	Веб хандалт www.mram.gov.mn/		115 000

- Олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдэд 86 ярилцлага, 30 орчим мэдээ, мэдээлэл өгсөн.
- Байгууллагын веб хуудсанд нийт ажилтан албан хаагчдын утасны жагсаалт, e-мэйл хаягийг нээлттэй байрлуулсан.
- Кадастрын веб хуудсыг бий болгох, байгууллагын веб серверт албан ёсоор байрлуулахад бэлэн болсон.



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

48

№	Төслийн нэр	Хамтран хэрэгжүүлэгч	Төслийн зорилго	Санхүүжилт	Хугацаа
1	“Хойд-Төв-Зүүн Азийн 3 хэмжээст геологийн структурууд ба металлогени”	Монгол Улс, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКаЗУ	Хойт-Төв-Зүүн Азийн нутгийг хамарсан геологийн том тогтоцын хэмжээнд хийгдсэн геологи, ашигт малтмалуудын мэдээллийг нэгтгэн уялдуулах	329.9 сая төгрөг	I үе шат 2010-2013 он; II үе шат 2013-2020 он
2	Хангайн бүсийн зүүн урд хэсэгт геологийн судалгаа болон ашигт малтмалын хайгуул хийх төсөл	БНСУ-ын КИГАМ	Хангайн бүсийн зүүн урд хэсэгт геологийн судалгаа болон ашигт малтмалын хайгуул хийх	60 000 ам.доллар	2013 оны III/01-X/31
3	Уул уурхайн бохирдлыг тогтоох төсөл	БНСУ-ын КОИКА	Монгол улсад уул уурхайн үйл ажиллагааны улмаас бохирдолд орсон газрын судалгаа хийх, мэдээллийн сан үүсгэх, лаборатори байгуулах	3 сая ам.доллар	2011 оноос эхлэн 3 жил



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

49

№	Төслийн нэр	Хамтран хэрэгжүүлэгч	Төслийн зорилго	Санхүүжилт	Хугацаа
4	Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлэх техникийн туслалцааны төсөл	Дэлхийн банк	АМГ-т бие даасан вэб серверийг байгуулж геологи уул уурхайн кадастрын компьютержсэн системийг бий болгох	423 695 ам.доллар	2013 онд дуусна /2 жил/
5	Тогтвортой бичил уурхайн төсөл	Швейцарийн хөгжлийн агентлаг	Бичил уурхайн эрх зүйн орчныг бүрдүүлэх, ил тод, шударга бодлого, зохицуулалтын орчин бий болгоход дэмжлэг үзүүлэх, бичил уурхайчдыг нийгмийн хариуцлагатай, үр ашигтай байх зохион байгуулалтад оруулах	I үе шат 2005-2007 он: 1.1 сая шв.Франк II үе шат 2007-2010 он: 2.9 сая шв.Франк III үе шат 2010-2014 он: 4.98 сая шв.Франк	
6	Монгол Алтай-50” 1:50 000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил	БНЧехУлсын Геологийн алба	Сонгосон талбайд 1:50000-ны масштабтай геологийн зураглал, геохимийн эрлийн ажлыг гүйцэтгэх	746.000 ам.доллар	2013 оны IV/09-2016 оны VI/30



ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

50

Бодлого, хуулийн төсөлд санал өгсөн байдал	Стандарт, дүрэм журам	Дотоодод мөрдөгдөх дүрэм, журам
<ul style="list-style-type: none"> - Эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, - Нүүрсний салбарт төрөөс баримтлах бодлого, нүүрс хөтөлбөр, - “Газрын хэвлийн тухай хууль” - Ашигт малтмалын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, - “Төрөөс хүнд үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийн төсөл, - Японы ЖАЙКА байгууллагын боловсруулж буй “Нүүрсний салбарыг 2025 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө”, - “Алтны худалдаанд ил тод байдлыг бүрдүүлэх тухай” хууль, - Гол мөрний урсац бүрдэх эх, ойн сан, усан сан бүхий хамгаалалтын газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, - “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль” - “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль” - “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хууль”, - “Газрын тухай хууль”, - “Газар албадан чөлөөлөх тухай хууль”, - “Газрын кадастрын тухай хууль” 	<p>Боловсруулсан:</p> <ul style="list-style-type: none"> • “Зэсийн баяжмал” MNS2079:2013 стандарт, • MNS ISO 11323:2011, MNS 6249:2011 стандартуудын төслийг боловсруулсан. • “Хүдэр, хүдрийн бус шороон ордыг далд аргаар ашиглах аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн төсөл, - “Ашигт малтмалыг баяжуулах, ялгах бутлах ба хүдэр, баяжмалыг бөөнцөглөх фабрикийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулах, - УУЯ болон БОНХЯ-ны холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран Байгаль орчны стандарт, аргачлал, журмуудыг шинээр болон шинэчлэн батлуулах ажлын даалгавар боловсрууллаа. <p>-Санал өгсөн:</p> <ul style="list-style-type: none"> - БОНХЯ-ны шинээр боловсруулж буй MNS B : 2013, MNS D : 2013, MNS F : 2013, MNS G : 2013 стандартуудад тус тус санал өгсөн. 	<ul style="list-style-type: none"> - Ашигт малтмалын газрын даргын 2013 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 408 дугаар тушаалаар “Уулын ажлын төлөвлөгөө тайлан хүлээн авах журам”-ыг батлан мөрдүүлж байна. - Ашигт малтмалын газрын даргын 2013 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 344 дүгээр, 2013 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 409 дүгээр тушаалаар тус тус Хөдөлмөрийн дотоод журамд зохих өөрчлөлт оруулж мөрдөн ажиллаж байна.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС



АЖЛЫН ХЭСГҮҮДЭД АЖИЛЛАСАН БАЙДАЛ

51

- Ерөнхийлөгч, УИХ, ЗГ-ын шийдвэрээр байгуулагдсан 20 гаруй ажлын хэсгүүдэд орж ажилласан байна.
- Уул уурхайн сайд, УУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдсан 80 орчим ажлын хэсэг, дэд хэсгүүдэд орж ажилласан байна.
- Агентлагийн даргын тушаалаар 20 ажлын хэсэг байгуулагдаж ажилласан.

Мөн:

- ҮХАА-н сайдын 2013 оны А/61 тоот тушаалаар байгуулагдсан “Бэлчээрийн газрыг эзэмшүүлэх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах журмыг боловсруулах” санл боловсруулах ажлын хэсэг,
- ТӨХ-ны даргын 2013/05/13-ны өдрийн А/123 тушаалаар байгуулагдсан “Уул уурхайн цогцолбор байгуулах төслийг хамтран хэрэгжүүлэх” ажлын хэсэг,
- УУ-н сайд, ЭЗХ-н сайд, ҮХАА-н сайдын 2013.09.27-ны өдрийн хамтарсан 199/69/А123 дугаар тушаалаар “Монгол зэс”, “Монгол төмөр” хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт орж, **мэдээ мэдээллээр хангаж, тодорхой санал, дүгнэлт өгч ажилласан байна.**



Шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг маргаан

52

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС



2013 онд шүүхээр шийдвэрлэсэн хэрэг маргаан

Нийт	Нэхэмжлэлийг хангасан	Хэрэгсэхгүй болгосон	Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн	Одоо хянагдаж байгаа
95	28	26	10	31



Авлигын эсрэг үйл ажиллагаа

53


- “Авлигын эсрэг үйл ажиллагааны 2012 оны тайлан болон 2013 оны төлөвлөгөө”-г батлуулан Авлигатай тэмцэх газар болон Уул уурхайн яаманд тус тус хүргүүлсэн.
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох дүрэм журмын талаар Агентлагийн төрийн захиргааны нийт албан хаагчдад сургалт зохион байгуулсан.
- Авлигатай тэмцэх газраас Ашигт малтмалын газарт хандан 2013 онд 79 албан бичиг ирүүлсэн байдаг ба тухай бүрд нь хариу хүргүүлж холбогдох арга хэмжээ авч ажилласан.
- Ашигт малтмалын газрын төрийн захиргааны албан тушаалтнуудын 2012 оны хөрөнгө, орлогын мэдүүлэг /хураангуй/-ийг 2013 оны 02 дугаар сарын 15-ны байдлаар бүрэн хамруулан хүргүүлсэн.
- Хөрөнгө, орлогын мэдүүлэгт их хэмжээний өөрчлөлт орох тухай бүрд албан тушаалтнуудаас мэдүүлгийг гаргуулан авч бүртгэл хөтлөн ажиллаж байна.



Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

54

(сая төгрөгөөр)



2013 онд Улсын төсвийн орлогыг бидний тооцоолж төлөвлөснөөс **11,2** тэрбум төгрөгөөр шууд нэмэгдүүлэн баталсан, хайгуулын тусгай зөвшөөрөл олгох, шилжүүлэхийг хориглосон, тусгай зөвшөөрлийн тоо эрс буурсан зэрэг шалтгааны улмаас 2013 оны хүлээгдэж буй гүйцэтгэл 39,0 орчим тэрбум төгрөг буюу 89,4%-тай байна.




БАТЛАГДСАН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

55

Батлагдсан зардлын гүйцэтгэл:

Байгууллагын 2013 оны батлагдсан зардлын хүлээгдэж буй гүйцэтгэл:



Батлагдсан зардлыг жил бүр хэмнэж ирсэн. 2013 оны зардлын хүлээгдэж буй гүйцэтгэл 2 тэрбум 418 сая төгрөг.



Дүгнэлт

56

➤ 2013 онд:

№	Бүтээгдэхүүний ангилал	Нийлүүлбэл зохих	Нийлүүлсэн		
			Бүрэн ханган нийлүүлсэн	Дутуу биелэлттэй	Тасарсан
1	Тусгай бүтээгдэхүүн	25	24	1	-
2	Нийт бүтээгдэхүүн	74	73	1	-
3	Манлайлалын зорилт	5	5	-	-
4	Нийт	104	102	2	-

1. Тусгай бүтээгдэхүүн 5.1-т заасан “Улсын төсөвт 43,6 тэрбум төгрөгийг төвлөрүүлэх” ажлын хүлээгдэж буй гүйцэтгэл 90,0 орчим хувьтай байна.

2. Нийт бүтээгдэхүүн 2.10-т заасан “Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэх” ажлын хүрээнд холбогдох ажлын хэсгийг байгуулан, төслийг боловсруулахад оролцсон уг хууль одоог УИХ-аар эцэслэн батлагдаагүй байна.йн байдлаар



Дүгнэлт

57

- Улсын төсвийн хөрөнгөөр нийт 62 төсөл хэрэгжиж байгаагаас 2013 онд 22 төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцэн хүлээж авсан.
- Хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохгүй болсон болон бусад хууль тогтоомжууд гарсантай холбогдуулан хайгуулын ажлын төлөвлөгөө, тайлан ирүүлэх байдал ихээхэн багассан. Хайгуулын ажилд зарцуулах зардал, хөрөнгө оруулалт үлэмж хэмжээгээр багасч байна.
- Уул уурхайн үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа техник, технологид үнэлэлт өгөх ажлын хүрээнд төмрийн уурхай, үйлдвэрүүдийн техник, технологийн түвшингийн судалгаа хийж санал дүгнэлт боловсруулсан.
- Бичил уурхайн нэгдсэн мэдээллийн цахим санг шинээр бий болгосон.
- Кадастрын бүртгэлийн системийг интернетийн орчинд байршуулах ажлыг хийж, кадастрын үйл ажиллагаатай үйлчлүүлэгч цахим хэлбэрээр танилцаж мэдээлэл авах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн.
- Кадастрын хэлтэс нь чадварлаг, цомхон бүтцэд шилжин ажилласнаар ажилтнуудын ажил үүргийн давхардал арилж, ажлын ачаалал жигдрэн, шат дамжлага багасч иргэд, аж ахуйн нэгжид хүрэх үйлчилгээ шуурхай, чанартай болсон.



Дүгнэлт

58

- Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 1278 аж ахуйн нэгжүүд, түүнчлэн идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй 354 уурхай болон үйлдвэрүүдийн дэлгэрэнгүй судалгаа хийж, мэдээллийн сангаа баяжууллаа.
- Нүүрсний 56 орд, үйлдвэрүүд тус бүрийн нарийвчилсан дэлгэрэнгүй судалгааг хийж гүйцэтгэсэн.
- Байгууллагын хүний нөөцийг чадваржуулах ажлын хүрээнд 30,0 орчим сая төгрөгөөр 70 гаруй албан хаагчийг сургалт, давтан сургалтад хамруулсан.
- Албан хаагчдын ажиллах нөхцөл боломжийг хангаж, нийт 8 өрөө тасалгааг засаж тохижуулсан.
- 2013 оны батлагдсан зардлыг 72,0 сая төгрөгөөр хэмнэж ажилласан.
- Хуулийн хэрэгжилтийг ханган, удирдлагын зүгээс тогтмол хяналт тавьж, зөвлөмж өгч ажилласнаар алдаа зөрчлийн тоо багасч, шүүхээр шийдвэрлэгдэх хэрэг маргааны тоо буурсан.



Дүгнэлт

59

-Албан хэрэг хөтлөлтийн журам боловсруулж, энэ чиглэлээр удаа дараа сургалт зохион байгуулснаар албан бичиг төлөвлөлт, боловсруулалт сайжирч хариутай албан бичгийн хугацаандаа шийдвэрлэгдсэн байдал сайжирсан.

- Мэдээллийн ил тод байдал хангагдаж цахим хэлбэрт шилжсэн.

- УИХ, ЗГ, УУЯ, Үндэсний аудитын газар зэрэг удирдах дээд байгууллагаас хийгдсэн удаа дараагийн шалгалтуудад амжилттай хамрагдсан.

- Хяналт шинжилгээний ажлын хүрээнд дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгож, газрын үйл ажиллагааны үр дүн, үйлчилгээг сайжруулахад чиглэсэн хэд хэдэн ажил санаачлан хэрэгжүүлсний зэрэгцээ АМГ-ын статистик мэдээллийн сан бүрдүүлж, уул уурхайн салбарын статистик мэдээг сар тутам гаргаж хэрэглэгчдэд түгээж хэвшлээ.

- Мөн түүнчлэн бодлогын баримт бичгүүд, хууль тогтоомж, холбогдох эрх зүйн актын хэрэгжилт, үйл ажиллагааны тайланд тогтмол үнэлгээ хийснээр газрын үйл ажиллагааны гүйцэтгэл сайжирч, үр дүн нэмэгдэж, хариуцлага өндөржсөн.



**ЦААШДЫН
ЗОРИЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ
АСУУДЛУУД**



Цаашдын зорилт

- Ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөнийг хөтөлж нэгдсэн мэдээллийн сантай болно;
- Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг нэмэгдүүлж, гүйцэтгэлийн чанарыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авч ажиллана.
- Хувийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа ГХА-ын төлөвлөгөө тайланг цахим хэлбэрээр хүлээн авч, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллана;
- Геологи ашигт малтмалын мэдээллийн санг бүртгэлийн хэлбэрээс тоон боловсруулалтын хэлбэрт шилжүүлнэ;
- Эрдэс баялгийн салбарын татварын ачааллыг тооцоолон, татварын таатай орчин бүрдүүлэхэд чиглэсэн мэдээлэл судалгаагаар хангаж ажиллана;
- Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортлох болон байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж буй компаниудыг дэмжиж ажиллана,



Цаашдын зорилт

- Ашигт малтмалын зах зээлийн үнэ, уул уурхайн салбарын хэтийн төлөвийн судалгаа хийж санал дүгнэлт боловсруулах;
- Бичил уурхайн эрх зүйн орчинг боловсронгуй болгох,
- Уул уурхайн бүтээгдэхүүний ангилал, стандартын төсөл боловсруулах,
- Нүүрс, шатдаг занарын олборлолт, боловсруулалтын технологийн мэдээллийн санг бүрдүүлэх,
- Гол мөрний урсац бүрдэх эх, ойн сан, усан сан бүхий хамгаалалтын газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуульд хамрагдсан тусгай зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлүүлэх
- Геологи, уул уурхайн компьютержсэн кадастрын системийг интернетэд байршуулж кадастрын үйл ажиллагааг богино хугацаанд түргэн шуурхай, нийтэд хүртээмжтэй болгох,



Цаашдын зорилт

- Ажилтан албан хаагчдын нийгмийн асуудлыг тодорхой хэмжээгээр шийдвэрлүүлэхэд анхаарч ажиллах;
- Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн батлуулахад анхаарч ажиллан, хууль батлагдсан тохиолдолд дагалдах дүрэм журмуудыг шинэчлэх;
- Албан хаагчдын ажлын ачааллыг нягтруулах, ажлын байрны тодорхойлолтыг боловсронгуй болгох;
- Ухаалаг төрийн бодлогыг хэрэгжүүлж, цомхон чадварлаг бүтцийг бий болгох;
- Хүний нөөцийн чадавхийг сайжруулах ажлын хүрээнд сургалт, давтан сургалтад нийт албан хаагчдыг хамруулах;
- Хуулийн хэрэгжилтийг хангуулж ажилласнаар иргэд, аж ахуйн нэгж байгууллага, үйлчлүүлэгчдээс шүүхэд хандах хандлагыг бууруулах;
-



Цаашдын зорилт

64

- Авлигатай тэмцэх төрийн бодлогыг хэрэгжүүлж ажиллах;
- Олон нийтэд салбарын талаар үнэн зөв, эерэг ойлголт өгч, хэвлэл мэдээллийн сурталчилгааг чанаржуулж ажиллана;
- Байгууллагын соёлыг төлөвшүүлэх хүрээнд олон талын сургалтуудыг зохион байгуулна

Газар, алба, хэлтсүүдийн эрсдлийн үнэлгээг хийх, гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулан, үйл ажиллагааны доголдлоос урьдчилан сэргийлэх, улмаар байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр ашгийг сайжруулах,

- АМГ-ын статистик мэдээллийн санг баяжуулж, хэрэглэгчдийн хүрээг нэмэгдүүлж, уул уурхайн салбарын гол мэдээлэл, судлагаа, статистик мэдээ бүхий товхимол хагас жил тутам бэлтгэн гаргах.



Тулгамдаж буй асуудлууд

- Геологийн ажлын санхүүжилт нь цаг хугацаандаа хийгдэхгүй байгаагаас тухайн судалгааны ажлын чанарт ихээр нөлөөлж байна,
- Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хариуцлагын тогтолцоог тодорхой болгох,
- Улсын төсвийн болон хувийн хөрөнгөөр ГСА гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүдийн хээрийн судалгааны ажлыг тогтвортой явуулахад орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлдэг болгох;
- Шүүхийн шийдвэрээр цуцлагдсан 106 тусгай зөвшөөрлийг Ашигт малтмалын тухай хуульд нийцүүлэн сэргээх асуудлыг шийдвэрлүүлэх;
- ЗГ-ын 194 дүгээр тогтоолд хамаарах ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон талбайн солбицлыг тодорхой болгох;
- Хөдөө орон нутагт томилолтоор ажиллах, туулах чадвар сайтай автомашины тоог нэмэгдүүлэх, парк шинэчлэл хийх,



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР

66

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА!

Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр
Улаанбаатар 15170, Монгол Улс
Утас: +976-51-263701
Факс: +976-11-310370

E-mail: cooperation@mram.gov.mn